



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 188

Улаанбаатар  
хот

## Журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50.11, 50.13-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг хэвсралт ёсоор баталсугай.
2. Мөнгөн урамшуулал олгоход шаардагдах зардлыг 2023 оноос үе шаттайгаар улсын төсөвт тусгаж шийдвэрлэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.
3. Энэ тогтоолыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

Монгол Улсын Шадар сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

С.АМАРСАЙХАН

Засгийн газрын 2022 оны 188 дугаар  
тогтоолын хавсралт

**АЙМГИЙН ТӨВӨӨС БУСАД СУМАНД ТАСРАЛТГҮЙ ТАВ БОЛОН ТҮҮНЭЭС  
ДЭЭШ ЖИЛ АЖИЛЛАЖ БАЙГАА ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН  
АЛБА ХААГЧИД МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал (цаашид "мөнгөн урамшуулал" гэх)-ыг олгоход энэ журмыг мөрдөнө.

**Хоёр. Мөнгөн урамшуулал олгох хугацаа, хэмжээ**

2.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагч (цаашид "алба хаагч" гэх) аймгийн төвөөс бусад суманд томилогдсон өдрөөс эхлэн тасралтгүй 60 сар ажилласан бол түүнд таван жил тутам нэг удаа мөнгөн урамшуулал олгоно.

2.2. Мөнгөн урамшуулал тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтооходоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 60 сарын дунджаар тооцно. Энэ үндсэн цалингийн дунджийг 30 сараар үржүүлж мөнгөн урамшууллын хэмжээг тогтооно.

2.3. Аймгийн Онцгой байдлын газар тухайн алба хаагчийн ажилласан хугацаа, албан тушаалын сарын үндсэн цалинг үнэн зөв тодорхойлно.

**Гурав. Мөнгөн урамшуулал олгох**

3.1. Энэ журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан алба хаагч мөнгөн урамшуулал авах хүсэлтээ тухайн аймгийн Онцгой байдлын газарт бичгээр гаргана.

3.2. Аймгийн Онцгой байдлын газар тухайн алба хаагчийн хүсэлт, ажилласан хугацаа, сүүлийн 60 сарын албан тушаалын үндсэн цалингийн хэмжээг тодорхойлсон тодорхойлолт, томилогдсон тушаал, шийдвэр (шаардлагатай тохиолдолд архивын лавлагаа)-ийн хуулбарын хамт онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.

3.3. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ирүүлсэн баримт бичгийн бүрдэл, алба хаагчийн ажилласан жилийг хянаж, баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногт багтаан мөнгөн урамшуулал олгох эсэх шийдвэрийг гаргана.

3.4. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг үндэслэн урамшууллын мөнгийг тухайн алба хаагчийн дансанд 30 хоногийн дотор шилжүүлнэ.

3.5.Энэ журмын 2.1-д заасан нөхцөлийг хангаж, мөнгөн урамшуулал авах хүсэлт гаргасан алба хаагч нас барсан тохиолдолд мөнгөн урамшууллыг түүний гэр бүлд нь олгоно.

3.6.Аймгийн Онцгой байдлын газар мөнгөн урамшуулал олгох алба хаагчийн тоо, шаардагдах зардлын хэмжээг тооцон онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 1 дүгээр сард багтаан хүргүүлнэ.

3.7.Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мөнгөн урамшуулалд шаардагдах зардлыг байгууллагынхаа жил бүрийн төсөвт тусгана.

#### Дөрөв.Бусад

4.1.Энэ журмын 2.1-д заасан тасралтгүй 60 сар ажилласан хугацаанд Төрийн албаны тухай хуулийн 42.1.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 60.1.3, 60.1.5, 60.1.12-т заасны дагуу ажил үүргээ гүйцэтгээгүй хугацааг оруулахгүй.

4.2.Алба хаагчийн ажилласан хугацаа, үндсэн цалингийн дундаж хэмжээг буруу тодорхойлох, хуурамч баримт бичиг бүрдүүлэх зэргээр мөнгөн урамшууллын хэмжээг буруу тогтоож олгосон эсхүл авсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.